



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 03 өдөр

Дугаар А/798

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.1 дэх заалт, Аймгийн агаар, орчны бохирдлыг бууруулах дэд хөтөлбөрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн А/246 дугаар тушаалаар 400,000,000 төгрөг /дөрвөн зуун сая/, 2019 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/117 дугаар тушаалаар 800,000,000 төгрөг /найман зуун сая/-ийг аймгийн агаар орчны бохирдлыг бууруулах арга хэмжээнд зарцуулах эрхийг аймгийн Засаг даргад тус тус шилжүүлсэн бөгөөд уг санхүүжилтээс санхүүжүүлэх зорилгоор төсөл сонгон шалгаруулалт явуулсан дүн, байгуулсан гэрээ, санхүүжилтийн эрхийг үндэслэн хавсралтанд заасан аж ахуйн нэгжүүдэд холбогдох санхүүжилтийг олгосугай.

2. Зээл олгох аж ахуйн нэгжийг хавсралтаар баталсугай

3. Дээрх арга хэмжээнд зарцуулах 300,000,000 төгрөг /гурван зуун сая/-ийг Агаар, орчны бохирдлыг бууруулах дэд хөтөлбөр, зээлийн гэрээ, хүү төлбөр, эргэн төлөх хуваарь зэргийг үндэслэн "Байгаль орчин аялал, жуулчлалын сайдын тушаалаар эрх шилжин ирсэн зардал"-аас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргыг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/ нарт зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/798 Ch

02. 03888

Аймгийн Засаг даргын 2019 оны
11 дүгээр сарын 08-ны өдрийн
А/798 дугаар захирамжийн хавсралт.

АЙМГИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛЫГ БУУРУУЛАХ ХӨТӨЛБӨРИЙН
ХҮРЭЭНД ЗЭЭЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ЖАГСААЛТ

Д/д	Аж ахуйн нэгжийн нэр	Зээл олгох болон эргэн төлөх хугацаа	Төслийн нэр	Олгох санхүүжилт
1.	Батдайчин ХХК	Олгох: 2019 оны 11 сарын 15-нд 150,000,000 төгрөг /нэг зуун тавин сая/ Төлөх: 2020 оны 02 сарын 15-нд	Батмонгол хаус хороолол төсөл	150,000,000
2.	Алтан орд констракшн ХХК	Олгох: 2019 оны 11 сарын 15-нд 150,000,000 төгрөг /нэг зуун тавин сая/ 2020 оны 2 сарын 15-нд 150,000,000 төгрөг /нэг зуун тавин сая/ Төлөх: 2021 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр	12 айлын жишиг амины орон сууц төсөл	300,000,000
	Нийт дүн			450,000,000

-oOo-